



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1995 оны 07 дугаар
сарын 20 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар
хот

"Өргөө зочид буудал" компани
шинээр байгуулах тухай

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын харьяалалд "Өргөө зочид буудал" компани /УУГ/ байгуулж, дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2. "Өргөө зочид буудал" компанийн ерөнхий захирлаар Жанчивдоржийн Жигжидсүрэнг 1995 оны 7 дугаар сарын 25-наас эхлэн томилон ажиллуулж сарын цалинг 30300 төгрөгөөр тогтоосугай.

3. "Өргөө зочид буудал" компани эхлэн үйл ажиллагаа явуулахад хөрөнгийн эх үүсвэргүй байгааг харгалзан эргэж төлөгдөх нөхцөлтэй гэрээ байгуулж зохих хөрөнгийн дэмжлэг үзүүлэхийг Санхүүгийн хэлтэс /н.Тонгор/, Өмчийн газар /н.Найдан/-т зөвшөөрсүгэй.

4. Өргөө зочид буудалд төр захиргааны байгууллага, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Харьяа газар, хэлтсийн шугамаар ирж буй зочид төлөөлөгчдийг хүлээн авч үйлчлэн дотоод зохион байгуулалт, дэг журмыг сайтар хангаж, шаардлагын дагуу ажиллахыг "Өргөө зочид буудал" компани /н.Жигжидсүрэн/-д үүрэг болгосугай.

5. "Өргөө зочид буудал" ашиглалтанд шинээр орж байгаагаар холбогдуулан тус зочид буудлын үйлчилгээний үнэ тарифийг хянан баталж өгөхийг Үнийн зөвшлийн комисс /н.Панбаатар/-т даалгасугай.


6. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1993 оны А/113 тоот захирамжийн 2 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.Баасанжав

Ц.БААСАНЖАВ



Нийслэлийн Засаг даргын 1995 оны
дугаар сарын 20-ны өдрийн 7/15
төрт захирамжийн хавсралт

"ӨРГӨӨ ЗОЧИД БУУДАЛ" КОМПАНИЙН /УТ/
ДҮРЭМ УХБ" II

Нэг. Нийтлэг үндэсдэл

1. "Өргөө зочид буудал" компани нь бие дааж үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах Улсын Үйлдвэрийн газар мөн.

2. "Өргөө зочид буудал" компани нь өөрийн нэр бүхий тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, бие даасан тайлан тэнцэлтэй хуулийн этгээд мөн.

3. Компанийн үндсэн зорилт нь төр, захиргааны байгууллага, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, харьяа газар, хэлтсийн шугамаар ирж буй зочид төлөөлөгчдийг хүлээн авч, буудлаар үйлчлэн ресторан, баар, дэлгүүр ажиллуулж, зочдын амгалан тайван тав тухтай байдлыг бүрэн хангаж, соёлч боловсон үйлчилгээг хэвшүүлэхэд оршино.

4. Дүрэм батлуулж, бүртгүүлсэн өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулна.

Хоёр. Эрхлэх ажил

1. Гадаад дотоодын холбогдох байгууллагуудтай жуулчдыг харилцан солилцох, хүлээн авах,

2. Ресторан, баар ажиллуулах,

3. Бараа бүтээгдэхүүн борлуулах дэлгүүр нээж ажиллуулах,

4. Хүнсний зарим бүтээгдэхүүнийхээ хэрэгцээг хангах зорилгоор туслах аж ахуй эрхлэх,

5. Угаалга, Саун, биллярд зэрэг үйлчилгээ ажиллуулна.

Гурав. Удирдлага

1. "Өргөө зочид буудал" компанийн ерөнхий захирлыг нийслэлийн

2.

Засаг дарга томилж, чөлөөлнө.

2."Өргөө зочид буудал" компанийн ерөнхий захирал нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулан ажиллаж, ажлаа тус газарт хариуцан тайлагнана.

3."Өргөө зочид буудал" компанийн ерөнхий захирал нь өөрийн дэргэд захиргааны зөвлөлийг 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж болно.

4.Компанийн ерөнхий захирал аж ахуйн бусад нэгжийн гишүүн удирдлагын бүрэлдэхүүнд байхыг хориглоно.Харин хувьцаа эзэмшигч байж болно.

5.Ерөнхий захирал нь компанийг төлөөлж, дор дурьдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.ҮҮНД:

1.Компанийн нэрийн өмнөөс бусад байгууллага, иргэдтэй шууд харилцаж хөдөлмөр, иргэний болон бусад гэрээ хэлцэл байгуулна.

2.Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу компанийн /УУГ/-ын эд хөрөнгийг захиран зарцуулна.

3.Компанийн бусад албан тушаалтан болон салбар, нэгжийн удирдлагын томилох, чөлөөлөх, тэдгээртэй хөдөлмөрийн гэрээ байгуулах,

4.Үйлдвэрлэл, үйлчилгээний дотоод журам батлан мөрдүүлж, биелэлтийг зохион байгуулж ажиллана.

5.Компанийн үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох,

6.Компанийн ерөнхий захирал Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал, заавар гаргана.Тушаал зааврыг тухайн үйлдвэрийн газрын үйл ажиллагааны хүрээнд мөрдөнө.

7.Компанийн мэдэлд үлдэх цэвэр ашгаас тодорхой хэмжээгээр шагнал, урамшил авах эрх эдлэнэ.

8.Монгол улсын хууль тогтоомж, байгууллагуудын тогтоол шийдвэр биелүүлэх, банк, санхүү, статистик зэрэг холбогдох байгууллагад тогтоосон журмын дагуу мэдээ тайлан гаргах үүрэг хүлээнэ.

9.Хөдөлмөр хамгаалал, техник, галын аюулгүй байдлын ажиллагааны дүрэм заавруудыг мөрдүүлнэ.

10.Ажилтан ажилчдын ахуй хангамж, хөдөлмөрлөх нөхцлийг байнга сайжруулан цалин, шагналт цалингийн системийг боловсруулан мөрдүүлж ажиллана.

11.Үйлдвэрлэл, үйлчилгээнд үнэ материал зарцуулалтын норм, норматив, стандарт мөрдөж, техникийн нөхцөл стандартыг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хянуулах.

12.Өөрийн үйл ажиллагааны явцад гарсан аливаа дутагдал доголдлыг цаг тухайд нь илрүүлэн тодорхой арга хэмжээ авч шийдвэрлэнэ.

Дөрөв.Дүрмийн сан

Өргөө компанийн дүрмийн сан нь бүгд 146,0 сая төгрөг, үүнээс компанийн байрны /м-100-р байрны 6-р орц/ анхны үнэ нь 57,2 мянган төгрөг үүн дээр хөрөнгө оруулалт хийж засварласан бөгөөд барилга байгууламж бүгд 84 сая төгрөг, тавилга төхөөрөмж 62,0 сая төгрөг байна.

Тав.Гадаад худалдааны эрх

Өргөө компани нь эдийн засгийн гадаад харилцаанд бие даан оролцох эрхтэй.

Зургаа.Татан буугдах

1.Өргөө зочид буудал компани нь Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр татан буугдана.

Долоо.Оршин байгаа газар

1.Өргөө зочид буудал компани нь Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн I хорооны нутаг дэвсгэрийн м-100 дугаар байрны 6-р орцонд байрлана.

Найм.

"Өргөө зочид буудал" компани нь хуулийн дагуу харьяа салбар төлөөлөгчийн газар байгуулж болно.